


Төлөвлөгөө боловсруулсан:
“ХАЛНИТ” ХХК

“ХАЛНИТ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ
“УУЖИМБУЛАГ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



ГАРЧИГ

1.	ОРШИЛ	5
2.	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	6
2.1.	Төслийн талбайн байршил	6
2.2.	Ашиглалтын системийн сонголт, уул техникийн нөхцөл	7
2.3.	Ил уурхайн хаягдал, бохирдол болон үйлдвэрлэлийн нөөц	7
2.4.	Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим	8
2.5.	Уурхайн хүчин чадал	8
2.6.	Уурхайн шимт хөрс хуулалт	8
2.7.	Ил уурхайн хөрс хуулалт ба овоолгын ажлын төлөвлөгөө	9
2.8.	Ил уурхайн процесс	10
2.8.1.	Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл	10
2.8.2.	Хөрс хуулалт болон элс хайрга олборлолтонд ажиллах экскаваторуудын бүтээлийн тооцоо	10
3.	ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ 11	
3.1.	Уур амьсгал	11
3.2.	Агаарын чанарын төлөв байдал	11
3.3.	Усан орчны төлөв байдал	13
3.4.	Хөрсөн орчны төлөв байдал	15
3.5.	Ургамлан нөмрөгийн хэв шинж	15
3.6.	Түүх соёлын өв болон тусгай хамгаалалттай газар нутаг	17
3.7.	Төслийн талбай орших нутгийн нийгэм эдийн засгийн төлөв байдал	17
3.8.	Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох, гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний товч тодорхойлолт	17
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024	19
4.1.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	19
4.2.	Хамрах хүрээ	19
4.2.1.	Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 БОМТ -нд өгсөн санал	19
4.3.	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ 2024	21
4.4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	25
4.5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
4.6.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25
4.7.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	25

4.8.	Тэрбум мод	25
4.9.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
4.10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
4.11.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
4.12.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32
5.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	33
5.1.	Агаар орчин	33
5.1.1.	Хяналт шинжилгээ явуулах шаардлага:	33
5.1.2.	Газрын гадарга, хөрсөн бүрхэвч	33
5.1.3.	Ургамлан нөмрөг	33
5.1.4.	Усны чанар, нөөц	33
5.2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	37
6.	ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	38

ХҮСНЭГТИЙН ДУГААРЛАЛТ

Хүснэгт 1.	Төслийн товч хураангуй	6
Хүснэгт 2.	Төслийн талбайн байршил орчмын солбицол	6
Хүснэгт 3.	Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа	8
Хүснэгт 4.	Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	9
Хүснэгт 5.	Ил уурхайн шимт хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө /мян.м3/	9
Хүснэгт 6.	Ил уурхайн хөрс овоолгын ажлын төлөвлөгөө /мян.м3/	9
Хүснэгт 7.	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	21
Хүснэгт 8.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн ажил	25
Хүснэгт 9.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 11.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
Хүснэгт 12.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ	32
Хүснэгт 13.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	35

ЗУРГИЙН ДУГААРЛАЛТ

Зураг 1.	Төслийн талбайн байршил харуулсан зураг	7
Зураг 2.	Ил уурхайн технологийн процесс	10
Зураг 3.	Гадаад орчны агаар дахь дуу чимээ, тоос, тоосонцрын хэмжилтийн хяналтын цэгийн байршил	12

Зураг 4. Судалгаанд ашиглагдсан багаж, тоног төхөөрөмж, хэмжилт хийсэн үеийн зураг.	13
Зураг 5. Төслийн талбайн байршилтай холбогдох уст цэгийн хязгаарлалтын бүс.....	14
Зураг 6. Төслийн талбайн агаар сансарын зураг, төслийн талбай голоос алслагдсан зайг харуулсан зураг.....	14
Зураг 7. Төслийн талбайд хийсэн ургамлын бичиглэл, тус булчээрт зонхилон ургасан ургамлын зураг	16
Зураг 8. Орчны хяналт шинжилгээний цэгүүд	34

1. ОРШИЛ

“Халнит” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Уужимбулаг нэртэй элс хайрганы ордыг ил аргаар ашиглах” төсөл нь Дархан-Уул аймгийн Дархан сумын Малчин багийн нутаг дэвсгэрт байрлах бөгөөд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нийт 124.37 га талбайд 30 жилийн хугацаанд олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна.

Энэхүү төсөл нь 2021 оны 12 сарын 30-ны өдөр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан батлагдаж 2022 оноос хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд мөн 2023 онд үйл ажиллагаа явуугүй. Учир нь тухайн төслийн нарийвчилсан үнэлгээ батлагдсан хэдий тухайн газарт ажиллахад эдийн засгийн хүндрэл тулгарсан бөгөөд тухайн талбайд 2024 оноос эхлэн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдөөд байна.

Уурхайн уулын ажлын хүрээнд нийт нөөцийг 30 жилийн хугацаанд 1,004.31 мян.м³ хөрс хуулж 3,668.13 мян.м³ элс хайрга олборлох ба 4,672.44 мян.м³ уулын цулын ажил хийгдэнэ. Хөрс хуулалтын коэффициент дунджаар 0.27 м³/м³ байгаа нь түгээмэл тархацтай ордын уулын ажил явуулахад хүндрэл багатай олборлолтын ажил нэгэн жигд ажиллах боломжтой гэж ТЭЗҮ-нд тусгасан байна. Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ захиалагч байгууллагын өгсөн техникийн даалгаварт тусгаснаар жилд 126.0 мян.м³ элс хайрга олборлоно гэж тооцоолсон байна. “Уужим булаг” элс-хайрганы ордын 32 шурф малгалтаас авсан хайрганы ширхэглэлийн бүрэлдэхүүний үзүүлэлтээр нийт хайрга 15-20%, үүнээс +5-10 мм-ын хайрга 85%, +10-20 мм-ын 12% , хүртэл, +20-40 мм-ын хайрга 2%, түүнээс том нь 1%-ийг тус тус эзэлж байна.

2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төслийн товч хураангуй


№	Агуулга	Танилцуулга
1	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Халнит” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	1911021042
3	Регистрийн дугаар	5332656
4	БОННУ батлагдсан он	2021 оны 12 сарын 31
5	Төслийн хэрэгжих хугацаа	30 жил
6	Ажиллах хүчний тооцоо	
7	Дэд бүтэц	Бүх үүрэн телефоны сүлжээтэй, шороон замаар 2.1 км-т Дархан-Уул аймгийн Дархан сумын хучилттай авто замтай холбогдоно.
8	Холбоо барих утас	99066469
9	Холбоо барих e-mail хаяг	Iderbayr90@gmail.com
10	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-45000042 (ДА-003А)
11	Үйл ажиллагааны чиглэл	Түгээмэл тархацтай ашигт малтмал (уул уурхай)
12	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг, 5-р хороолол, 1в, 75 тоот

2.1. Төслийн талбайн байршил

“Халнит” ХХК-ийн ДА-003А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Уужимбулаг элс-хайрганы орд нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших бөгөөд Дархан хотын төвөөс баруун урагш 4.5 орчим км, Улаанбаатар хотоос баруун хойш 227 км-ын зайд байрлана. Нийт 124.37 га талбайд хэрэгжинэ.

Хүснэгт 2. Төслийн талбайн байршил орчмын солбицол

Дугаар	X	Y
1	105°55'31.16"	49°26'31.9"
2	105°55'31.16"	49°25'31.9"
3	105°54'51.02"	49°25'42.09"
4	105°54'51.17"	49°26'31.9"



Зураг 1. Төслийн талбайн байршил харуулсан зураг

2.2. Ашиглалтын системийн сонголт, уул техникийн нөхцөл

Тус ордын талбай нь ерөнхийдөө тэгшивтэр гадаргуутай буюу 670-680м хооронд хэлбэлзэнэ. Ашигт малтмалын нөөцийг тооцоолсон гүн нь 2.5-5.2 м буюу бага гүнтэй байна. Ашигт малтмалын биет хөрсний усанд автагдсан, усны төвшин нь гадаргуугаас 1.5-2.0м-ийн гүнд буюу дунджаар 674м-ийн горизонтод тогтоогдсон. Хөрсний ус нь Хараа голын устай гидравлик холбоотой, агаарын хур тунадсаар тэжээгддэг гэж судлаачид /Фрейдкина,1977/ үзсэн байна.

Дээрх уул техникийн нөхцөл, хөрсний зузаан, газарзүйн байрлал зэргийг үндэслэн ордыг ил уурхайн аргаар автотээвэртэй(тухайн нөхцөлд байдалд тулгуурлан зарим тохиолдолд автотээвэргүй), гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар сонгосон.

Ордыг олборлохдоо 0.2 м зузаантай шимт хөрсний үеийг тусад нь хурааж биологийн нөхөн сэргээлтийн үед ашиглах бөгөөд 1.25-2.3 м хүртэл гүнтэй хучаас хөрсийг талбайн зүүн хэсгээр буюу нөөц бодогдоогүй орон зайд овоолно.Овоолгын талбайн хязгаарлах нөхцөл нь тусгай зөвшөөрлийн хил болон ил уурхайн амсар болж байна.

2.3. Ил уурхайн хаягдал, бохирдол болон үйлдвэрлэлийн нөөц

Аливаа ашигт малтмалыг олборлоход геологи, техник технологи, эдийн засгийн хүчин зүйлүүдээс шалтгаалж газрын хэвлийд оршиж байгаа геологийн нөөцийг бүрэн хэмжээгээр ашиглаж чаддаггүй бөгөөд энэ нь ашиглалтын хаягдал үүсэх үндсэн нөхцөл болдог.

Хаягдал: Үйлдвэрийн нөөцийг тооцохдоо уурхайн хил хязгаар дахь геологийн нөөцөөс ашиглалтийн үеийн хаягдлыг хасч тооцов. Таацнаас гарах хаягдлыг элсэн чулууны давхрагийн таазнаас 0.1м –ээр авав. Уурхайн нийт хаягдал 72.53 мян.м³ буюу 1.99% -ийг эзэлж байна.

Бохирдол: Доголын хажуугийн өнцөг 30 градусаар авахад ордын хэмжээнд хажуу хананаас 13.94 мян.м³ элс хайрга нэмэгдэж байна.

2.4. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим

Элс-хайрга олборлолтын ажил 2024 оны 4-р сарын 1-ээс 10 сарын эхэн хүртэл хийнэ. Ил уурхай нь улирлын чанартай ажиллана. Уурхай нь хоногт нэг ээлжээр, ээлжинд 8 цаг ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

Үзүүлэлт	Х.н	2024 онд
Жилд ажиллах хуанлийн өдөр	хоног	90
Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	6
Засвар үйлчилгээ, цаг агаар болон бусад өдрүүд	хоног	10
Ажиллах өдөр	хоног	74
Нэг хоногийн ээлжийн тоо	хоног	2
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	хоног	8
Ээлж солилцох хугацаа	хоног	0

2.5. Уурхайн хүчин чадал

Календарьчилсан төлөвлөгөөг гаргахдаа нийт нөөцийг олборлох үед үүсэх уурхайн хил хүрээг гаргаж түүнд хамаарах хөрсний хэмжээнээс хөрс хуулалтын коэффициентоор тооцож гаргасан ба уг коэффициентийн дагуу 30 жилийн ашиглалтын тооцоог хийлээ.

Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ захиалагч байгууллагын өгсөн техникийн даалгаварт тусгаснаар жилд 126.0 мян.м³ элс хайрга олборлоно гэж тооцооллоо.

Шимт хөрс: Уурхайн ерөнхий төлөвлөлтийн дагуу ордын В-1 блокийн шимт хөрсийг хуулж эхэлнэ. 2,127 м³ шимтхөрс хуулж тусгайлан бэлтгэсэн шимт хөрсний овоолгод Монгол Улсын (MNS 5916:2008) стандартын дагуу түр овоолго үүсгэнэ. Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.15-0.2 м-ийн зузаантайгаар экскаватороор хуулан техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

Элс-хайрга олборлолт: Бэлтгэл ажлын хүрээнд В-1 блокоос нийт 3.454 м³ элс-хайрганы холимог олборлох ба тусгайлан бэлдсэн овоолгын талбайд овоолно.

2.6. Уурхайн шимт хөрс хуулалт

Уурхайн ерөнхий төлөвлөлтийн дагуу ордын В-1 блокийн шимт хөрсийг хуулж эхэлнэ. 2024 оны уурхайн ашиглалтын хугацаанд 0.2 мян.м³ шимт хөрс хуулж тусгайлан бэлтгэсэн шимт хөрсний овоолгод Монгол Улсын (MNS 5916:2008) стандартын дагуу түр овоолго үүсгэнэ. Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.15-0.2 м-ийн зузаантайгаар экскаватороор хуулан техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан овоолно. Энэ нь дотоод овоолгоор

техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм. Орд газрын тогтоц газрын гадаргын өндөршилийг харгалзан уурхайн хүрээг дагуулан үүсгэхээр төлөвлөсөн болно.

Хүснэгт 4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Элс-Хайрганы холимог	Ширхэглэл	Дундаж агуулга, %	Элсэн чулуун дахь ширхэглэлийн хэмжээ, м3	Ширхэглэлийн хувь
Хайрга мян.м ³	40<	1.03%	401.7	10%
	20_40	2.03%	791.7	20%
	10_20	1.68%	655.2	16%
	5_10	5.55%	2164.5	54%
	Нийт	10.29%	4013.1	100%
Элс мян.м ³	2.5_5	7.76%	3026.4	8.65%
	1.25_2.5	8.52%	3322.8	9.50%
	0.63_1.25	14.18%	5530.2	15.81%
	0.315_0.63	35.31%	13770.9	39.36%
	0.16_0.315	14.82%	5779.8	16.52%
	<0.16	9.12%	3556.8	10.17%
	Нийт	89.71%	34986.9	100%
НИЙТ		100.00%	39000	
Бусад	Шавар тоосонцор			
	Нийт уулын цул			
	Ашиглалын хаягдалын эзэлх хувь			
	Нэмэгдэх нөөцний эзлэх хувь			
	Нийт хөрс хуулалт			
	Шимт хөрс			
	Хөрс			
	Хөрс хуулалтын коэффициент			

2.7. Ил уурхайн хөрс хуулалт ба овоолгын ажлын төлөвлөгөө

Хөрс хуулалтын HUIINDAI 380C маркын 1,8 м³-ын шанагатай маркийн урвуу утгуурт экскаватор, Nowo 6x4 маркийн 25 тонн даацтай автосамосвал хослон хийнэ.

2024 онд нийт 2.09 мян.м³ шимт хөрс хуулж тусгайлан бэлтгэсэн шимт хөрсний овоолгуудад Монгол Улсын (MNS 5917:2008) стандартын дагуу хураана. Ил уурхайн хөрсийг автотээврээр гадаад овоолгуудад овоолох ба нийт 13 мян.м³ хөрс буюу сийрэгжсэн эзэлхүүнээр 18.2 мян.м³ хөрс овоолно.

Хүснэгт 5. Ил уурхайн шимт хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө /мян.м³/

Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нийт	2024 он
Шимт хөрс хуулалт	Мян.м ³	2.09	2.09


Хүснэгт 6. Ил уурхайн хөрс овоолгын ажлын төлөвлөгөө /мян.м³/

Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нийт	2021 он
Уулын цул	Мян.м ³	13	13
Сийрэгжсэн	Мян.м ³	18.2	18.2

2.8. Ил уурхайн процесс

2.8.1. Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Уурхайд хэрэглэх тоног төхөөрөмж, техникийг сонгохдоо захиалагч талын өгсөн техникийн даалгавар болон компанийн саналыг харгалзан дараах техникуудийг ашиглахаар тооцлоо. Үүнд Hyundai 380 маркийн экскаватор, SEM656 маркийн 3 м³ багтаамжтай шанагатай ачигч, 25 тн-ийн даацтай Howo маркийн автосамосвал 3-4 ш, ПА маркийн ялган ангилах төхөөрөмж-1 ш зэрэг тоног төхөөрөмжийг ашиглахаар ТЭЗҮ-н тооцоонд тусгасан болно.



Зураг 2. Ил уурхайн технологийн процесс

Инженерийн лавлах-5, практикум, Ил уурхайн авто тээвэр зэрэг номыг ишлэл болгон ашиглав./

2.8.2. Хөрс хуулалт болон элс хайрга олборлолтонд ажиллах экскаваторуудын бүтээлийн тооцоо

Уурхайд ажиллах экскаваторуудыг сонгохдоо тус ордыг ашиглах техникийн даалгавар, захиалагч талын тавьсан саналын дагуу “Халинит” ХХК-ний өөрийн хөрөнгөнд бүртгэлтэй дараах хүчин чадал бүхий HUIINDAI 3801c-9s маркын 1,8 м³-ын шанагатай 120 кВт хөдөлгүүрийн чадал бүхий экскаваторыг ашиглахаар тооцлоо.

Уг гидро экскаватор нь ижил төрлийн техникийн үзүүлэлт ижил боловч техник үйлчилгээ, шатахуун зарцуулалт зэрэг нь харьцангуй багатай нь давуу талтай юм.

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1. Уур амьсгал

“Халнит” ХХК-ийн ДА-003А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Уужимбулаг элс-хайрганы орд нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших бөгөөд төсөл хэрэгжих бүс нутгийн уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Төсөл хэрэгжих орчмын бүс нутаг нь уур амьсгалын эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Өвөл: Дархан уул аймагт өвлийн улирал 10 дугаар сарын 27-оос дараа оны 3 дугаар сарын 29 хүртэл 153 хоног үргэлжилж байна. Энэ нь манай орны нутгийн дундаж хугацаанаас арай урт байна. Өвлийн улирлын гол нь онцлог нь цаг агаар тогтуун болж, нарны өндөр хамгийн бага болж нарны тусгалын илч багасан, пасан бүрхүүл зузааран, хунгарлана. Хүйтний эрч туйлдаа хүрч зарим үед -47°C болох тохиолдол цөөнгүй.

Хавар: Хаврын улирал өвлийн төгсгөлөөс дунджаар 5 дугаар сарын 17 хүртэл 49 хоног үргэлжилдэг. Хаврын гол онцлог нь өвлийн цаг агаарын эсрэг циклонлог тогтоц задарч цаг агаарын шинж хувирамтгай болж хоног хоногоор дулаардагч хоногийн температурын агууриг бусад улирлынхаас ихсэж, хахиршил нэмэгдэж ялангуяа хаврын эхэн хэсэгт хүйтэн жавартай байдаг.

Зун: Зуны улирал дулааны шинжээрээ харьцангуй урт үргэлжилдэг. Манай орны бүс нутгуудын нэгэн адил зун 5 дугаар сарын 17-ноос эхлэн 9 дүгээр сарын 7 хүртэл 113 хоног үргэлжилнэ. Зуны улиралд агаар мандлын бага даралтын орон бүрэлдэх, хур тунадасны 75 орчим хувь нь унаж, ус чийг ихсэж зарим тохиолдолд аадар борооны нөлөөгөөр үер усны их буулт болж, замын далан болон гүүр гарцны зарим хэсэгт нөлөөлж болзошгүйг анхаарах шаардлагатай. Мөн дулааны хэмжээ туйлдаа хүрч хамгийн халуун нь $+38^{\circ}\text{C}$ хөрсний гадаргад $+65^{\circ}\text{C}$ хүрнэ. Заримдаа бүгчим халуун, аадар, аянга, ус, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдэл гарах магадлалтай байдаг.

Намар: Намрын улирад зуны төгсгөлөөс өвлийн эхэн хүртэл (7.IX-27.X) 50 хоног үргэлжилж өвлийн эхэн үед аажимдаа шилжинэ. Намрын уур амьсгалын байгаль орчны гол шинж нь хоног хоногоор сэрүүсч шүүдэр, хяруу унаж, цас мөсний үзэгдэл намрын эцсээр үүсч, хур татарч, газар шороо өнгөнөөсөө хөлдөж, өдөр богиносдог.

3.2. Агаарын чанарын төлөв байдал

Элс хайрганы орд газрын төслийн талбай дахь агаарын чанарын судалгааг 2020 оны 05 сарын 15 -ны өдөр хийж гүйцэтгэлээ. Төсөл хэрэгжихээс өмнө буюу өнөөгийн байдлаар төслийн агаар орчны чанарт үзүүлэх гол нөлөөлөл нь тээврийн хэрэгслийн утаа болон төслийн орчмын үйлдвэр, ДЦС-ын үнсний талбайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, дуу чимээ зэрэг юм. Төслийн талбай орчим нь Дархан хотын үйлвэржилтийн бүсэд байрлах ба Дархан хотын төмөрлөгийн үйлдвэрээс 2,5 км зайд байрлаж байна. Төслийн талбайн агаарын чанарын түвшинг тодорхойлох зорилгоор эдэлбэр газрын хил дотор 3 цэгт хэмжилт хийж, үр дүнг боловсруулав.


Баримтлах хууль, стандарт шаардлага.

- Агаарын тухай хууль
- MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5885:2008. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага

Судалгааны үр дүн.

Төсөл хэрэгжихээс өмнө буюу өнөөгийн байдлаар төслийн агаар орчны чанарт үзүүлэх гол нөлөөлөл нь тээврийн хэрэгслийн утаа болон төслийн орчмын үйлдвэр, ДЦС-ын үнсний талбайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, дуу чимээ зэрэг юм. Төслийн талбайн агаарын чанарын түвшинг тодорхойлох зорилгоор эдэлбэр газрын хил дотор 3 цэгт хэмжилт хийж, үр дүнг боловсруулахдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад, аргачлал болон багажит шинжилгээний аргыг ашиглан агаар бохирдуулагчийг тодорхойлсон. Агаарын чанарын хэмжилтийг хийхдээ агаарын чанарын хяналт шинжилгээний хугацаат ажиглалтын горимоор хэмжилт хийн холбогдох стандартуудтай харьцуулах, агаарын чанарын индексээр үнэлэх зэрэг аргыг ашиглав.

Судалгааны байршил.



Зураг 3. Гадаад орчны агаар дахь дуу чимээ, тоос, тоосонцрын хэмжилтийн хяналтын цэгийн байршил

№	Хэмжилтийн цэг	Уртраг	Өргөрөг
1	Эдэлбэр газрын хил дотор	105°54'58.789" E	49°26'24.649"N
2		105°55'26.493" E	49°26'2.531"N

Судалгааны багаж, тоног төхөөрөмж.

Гадаад орчны агаар дахь тоос, тоосонцрын хэмжилтийг нарийн ширхэглэгт тоосонцор (PM_{2.5}), том ширхэглэгт тоосонцор (PM₁₀), агаарын чийгшил, температур гэсэн

үзүүлэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн Temtop air quality 1000 багажаар 10 минут хэмжилт хийж тодорхойлов. Судалгааны үр дүнг агаарын чанар стандарт (MNS 4585:2016)-тай харьцуулж агаарын индексээр илэрхийлсэн. Гадаад орчны дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрлэсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн.




Зураг 4. Судалгаанд ашиглагдсан багаж, тоног төхөөрөмж, хэмжилт хийсэн үеийн зураг

3.3. Усан орчны төлөв байдал

Гадаргын ус: “Халнит” ХХК-ийн ДА-003А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Уужимбулаг элс-хайрганы орд нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших бөгөөд усзүйн хувьд Хойд мөсөн далайн голуудын ай сав Хараа-Ерөө голын сав газарт хамаарагдана. Төсөл хэрэгжих талбай болох Дархан Уул аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч Орхон голд цутгадаг Хараагийн голоос гадна Зулзага, Шарын гол, Ерөө, Орхон, Хүйтэн, Хавчуу зэрэг голуудтай. Уужимбулагийн элс-хайрганы орд нь Хараа голын баруун дэнжийн татам Уужимбулагийн хөндийн зүүн дэнжид оршино. Төслийн талбайгаас баруун тийш 230 орчим м-ийн зайд Хараа гол урсах бөгөөд тус гол нь Дархан хотоос хойш 20 орчим км-т Орхон голд цутгана. Харин түр зуурын урсацтай жижиг, том сайрууд элбэг тохиолдохын дээр уулс хоорондын хөндий, жалга, судагт 5.0 хүртэл метрийн гүнээс хөрсний ус, 30 ба түүнээс дээш метрийн гүнээс гүний ус илэрнэ. Хур бороотой үед устай байдаг томоохон сайрууд ч бий.



Зураг 5. Төслийн талбайн байршилтай холбогдох уст цэгийн хязгаарлалтын бүс



Зураг 6. Төслийн талбайн агаар сансарын зураг, төслийн талбай голоос алслагдсан зайг харуулсан зураг “Халнит” ХХК-ийн “Уужимбулаг элс-хайрганы орд ил аргаар ашиглах” төслийн талбай нь Хараа голын зүүн дэнжид байрлах бөгөөд тус голоос зүүн тийш 230 орчим м-ийн

зайд байрлана. Төслийн талбай нь Хараа голын болон энгийн хамгаалалтын бүсэд ороогүй боловч Хараа голын энгийн хамгаалалтын бүстэй ойр орших тул Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ыг дагуу усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай.

3.4. Хөрсөн орчны төлөв байдал

Судалгааны талбай нь Дархан-Уул аймгийн Дархан хотын нутаг дэвсгэрт байрлана. Төсөл хэрэгжих талбай орчим нь Дархан хотын хүн ам суурьшсан бүстэй ойр, хотын үйлдвэрийн төвлөрсөн бүсэд байрлана. Судалгаанд хамрагдсан Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах “Уужимбулаг нэртэй элс-хайрганы орд ил аргаар ашиглах” төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Орхон-Шаамарын тойрогт хамаарагдах бөгөөд төслийн талбайд тал хөндийн хөрсний хэв шинжийн нугат хүрэн хөрс тархана. Энэ хэвшинжийн хөрс Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий хотгорт өргөргийн ба хотгорын бүсэд тогтворжино. Зүсэлт хийсэн цэгийн орчимд хялгана-хиагт бүлгэмдэл тархах бөгөөд 40-50 хувийн бүрхэцтэй байна. Хөрсний өнгөн хөрсний зузаан 0-20 см, ширхэгийн бүрэлдэхүүнээр хөнгөн шавранцар байна. Газрын гадарга тэгш, налуужилт 0-4°, төслийн талбайн дундуур хойноос урагш чиглэсэн 3.4 км урттай сайр тогтсон, техноген болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд бага өртөгдсөн талбай байна.

Хээрийн бичиглэл.


- **Аймаг, хот:** Дархан-Уул аймаг, Дархан хот
- **Дүүрэг:** Малчин баг
- **Төслийн нэр:** “Уужимбулаг нэртэй элс-хайрга ил аргаар ашиглах ” төсөл
- **Байршил:** Хараа голын хойд хөндий
- **Гадарга** (зүг, налуу): 0-4°
- **Ургамал бүрхэвч, голлох төрлүүд:** Улалж >25%-үетэн алаг өвст >25% бүлгэмдэл
- **Хөрсний эвдрэл:** бага зэрэг
- **Үүсгэгч хүчин зүйл:** Техноген, шороон зам, антропоген, салхи, ус
- **Хөрсний нэр:** Тал хөндийн хөрс, нугат хүрэн хөрс

3.5. Ургамлан нөмрөгийн хэв шинж

Төслийн талбай нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах бөгөөд ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Чийглэгдүү хэвшинжийн Дорнод Азийн Орхон-Туулын нам уулсын тойрогт хамаарагдана. Төслийн талбай нь үетэн-алаг өвст-60, хиаг-улалжит-20, улалж-үетэн-алаг өвст -20 бүхий холимог нугат 3 бэлчээрийн төрөлд багтдаг.

Ургамлын бичиглэл үйлдэхдээ тухайн ургамалжилтын хэв шинжийг бүрэн илэрхийлж чадахуйц, төслийн талбайг бүрэн төлөөлж чадахуйц газрын гадарга нэгэн жигд байх талбайг сонгож геоботаникийн дэлгэрэнгүй бичиглэлийг Друдегийн аргаар үйлдэв. Ургамлын зүйл тус бүрийн арви, бүрхэц, үржлийн ба ургал найлзуурын өндрийг тэмдэглэхээс гадна үзэгдэл зүйн ямар үе шатанд байгааг тодорхой бичсэн. Бичиглэл хийх судалгааны талбай 10x10 м хэмжээтэй байх ба газрын нэр бүлгэмдлийн хэв шинж, тусгагийн бүрхэц, хөрсний төрөл, хайрга чулуу, элсэн бүрхэвчийн эзлэх хувь зэргийг

бичдэг. Талбайн ургамлын судалгааг явуулын аргаар явуулж, 2 цэгт геоботаникийн бичиглэл үйлдэв.



Зураг 7. Төслийн талбайд хийсэн ургамлын бичиглэл, тус бүлчээрт зонхилон ургасан ургамлын зураг
Төслийн талбай болон түүний орчимд тархсан бэлчээрийн хэвшинжийн онцлог, тархалтын мэдээллийг тус бүрд оруулав.

Голын чийглэг нугын улалж-үетэн алаг өвст бүлчээрийн төлөв байдал.

Тус бүлчээрт дараах ургамлын бүлгэмлүүд ургадаг. Үүнд:

1. Улалж >25%-үетэн алаг өвст >25% бүлгэмдэл зонхилно. Үетнээс туужууны биелэг, монгол улаан толгой, соргүй согоовор, сорлог хиаг зэрэг ариу ихтэйгээр зонхилохын зэрэгцээ хэвлэг гиш, шар царгас, гэрийн хошоонгор, эмийн сөд, эгэл шарилж, үхэр дэгд, жинхэнэ өрөмтүүл, хависхана навчит бэриш, дэлдэрхүү буржгар, салбант шарилж зэрэг алаг өвс элбэг ургадаг.
2. Түнгэ (10-25%)-улалж-агьт (<15%) бүлгэмдэл ургана. Хуурайшилтай нөхцөлд ашиглалтын нөлөө эрс нэмэгддэг.
3. Агь (>15%)-түнгэ(<10%)- алаг өвст бүлгэмдэл мөн ургана. Доройтлын индикатор алаг өвснүүд болох Буурал Гандбадраа, Имт гичгэнэ, Эгц түмэн тана ихсэхийн зэрэгцээ халцгай газрын хэмжээ ихэсдэг.

Бэлчээрийн соргог төлөв байдал. Энэ төрлийн бэлчээр том гол горхины татмын нугад тохиолдох ба хөрсний ус ойр чийглэг тул үндсэн төлөвтөө (1.1) олон зүйлийн улалж, монгол улаан толгой зэрэг чийгсэг үетэн бүхий гэрийн хошоонгор, гиш, царгас, сөд өвс зэрэг баялаг алаг өвст бэлчээр юм. Бэлчээрийн дунд зэрэг өөрчлөгдсөн төлөв байдал. Бэлчээрлэлт болон хуурайшилтын нөлөөгөөр өөрчлөлтөд орж үндэслэг ишт хуурайсаг ургамлууд болох Нангиад цагаан суль, ширэг улалж, агь түрж урган хээржүү бүлгэмдэлээр

(2.1, 2.2) солигддог. Үүний дараа дов сондуул хатаж хуурайшин, халцгай газрын хэмжээ ихсэж үет ургамлын үлдэгдэл бүхий хуурайшсан нуга болж хүчтэй доройтдог.

3.6. Түүх соёлын өв болон тусгай хамгаалалттай газар нутаг

Төсөл хэрэгжих талбай нь Дархан аймгийн Дархан хотын төвөөс баруун урагш 4.5 км орчим зайд байрлах бөгөөд төслийн талбайд одоогийн байдлаар түүх, соёлын дурсгал, археологи, палеонтологийн олдвор илрээгүй байдалтай байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

3.7. Төслийн талбай орших нутгийн нийгэм эдийн засгийн төлөв байдал

Дархан хот нь Дархан-Уул аймгийн засаг захиргааны төв болсон хот. Засаг захиргааны хуваарь ёсоор адил нэртэй сум болдог. 2018 оны тооцоогоор 105,923 оршин суугчтай бол метрополи газар нутагт 180,000 оршин суугчтай байна. Үүнээс үзвэл Улаанбаатарын дараах хоёр дахь том хот болох юм. Дархан хотод ойрын үед олон сайхан барилга байгууламж баригдсан. Эдгээр нь Морин хуур цогцолбор, Бурхантай уул, мөн хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх паркийг шинэчилж сайжруулсан. Дархан хотод тээврийн үйлчилгээний таксиний үйлчилгээг 10 компани, нийтийн тээврийн том оврын автобусаар үйлчилдэг нэг компани хангадаг. Дархан хот Улаанбаатар, Эрдэнэт хотуудыг бодвол амьдрах болон зорчих зарлага багатай, ажлын байр олдоц ихтэй, цэвэр агаар сайтай, сургууль цэцэрлэгийн хүрэлцээ хангалттай, харилцаа холбоо дэд бүтэц сайтай Монголын 2 дахь нийслэл хэмээгддэг хот юм. Дархан хотын анхны суурийн чулууг "Бурхантын хөндий"-д 1961 оны 10-р сарын 17- ны өдөр тавьсан бөгөөд тус хотыг хуучин социалист орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чехословак, Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулан хөгжүүлсэн юм. Мөн Япон улсын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтай Дарханы төмөрлөгийн үйлдвэр байгуулагдсан. Улсын Их Хурлын 1994 оны 32 тоот тогтоолоор Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон зохион байгуулсан ба Засаг захиргааны нэгжийн хувьд 4 сум (Дархан, Хонгор, Шарын гол, Орхон), 24 багтай. Дархан-Уул аймаг нь Сэлэнгэ аймгийн сумуудтай хил залгаа оршдог. Дархан хотыг шинэ Дархан, хуучин Дархан гэсэн 2 хэсэгт хуваадаг. Байгаль, газарзүйн онцлог: Дархан хот нь Орхон-Сэлэнгийн сав газрын бүсэд багтдаг. Хараа голын эрэг Бурхантын хөндийд оршдог бөгөөд далайн түвшнээс дээш 700 м-ийн өндөрт байрласан ба 327.5 мянган га газар нутагтай, эрс тэс уур амьсгалтай. Хүн ам. Дархан хот нь 2013 оны байдлаар 96,428 хүн амтай. Нийт хүн амын 64.5 хувийг 35 хүртэлх насны залуус эзэлдэг ба нийт өрхийн 67.5 хувь нь орон сууцанд амьдардаг.

3.8. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох, гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний товч тодорхойлолт

“Халнит” ХХК-ийн “Уужим булаг нэртэй элс-хайрганы орд ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг нөлөөлөлд өртөх газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, газрын доорх усанд нөлөөлж болзошгүй хэлбэрүүд, түүний шинж чанар зэргийг урьдчилсан байдлаар тодорхойлсон

бөгөөд мөн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэл, зарим зөвлөмж, саналыг товч тусгав.

Төслөөс байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Төслийн олборлолтын үе шатанд буюу хөрс хуулалт, тээвэрлэлт, хадгалалт болон баяжуулах үйл ажиллагааны үед салхины горим, нийлбэр цацрагийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийн улмаас үүсэх тоосонцор, шимт хөрснийг хадгалах газрын сонголт, дотоод овоолгоос үүсэх тоосонцорын тархалт зэрэгт нөлөөлөх;
- Уурхайн карьер, шимт хөрс, хөрсний гадаад, дотоод овоолго болон тээвэрлэлтийн үеийн тоосонцорын тархалт, автомашины утаанаас ялгарах бохирдуулагч бодисууд зэргийн агаар мандал дахь тархалт
- Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын гадаргын үндсэн хэлбэр дүрс их хэмжээгээр өөрчлөгдөж, гүн ухагдсан нүх, ил уурхайн ухааш болон хэт огцом налуутай өндөр овоолгуудаас бий болсон толгод, далан нурууг үүсгэх бөгөөд үүний улмаас тухайн өөрчлөлтөд орсон талбай нь газар ашиглалтын хувьд тохиромжгүй болж хувирах;
- Ахуйн бохир ус хөрсөнд алдагдах, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолтой усыг сумын ус зайлуулах шугамд нийлүүлэх;
- Орчны тоосжилтод байнгын хяналт тавьж, тоосжилтыг бууруулахын тулд салхи ихтэй, хуурайшилттай үед зам талбайг чийглэж услах;
- Шимт хөрсний овоолго ургамалжуулан хамгаалах. Энэ нь шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй байх мөн тоосжилт үүсэхээс сэргийлэх талтай;
- Газрын гадарга элэгдэл эвдрэлд өртсөнөөр хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, хөрс шүтэн амьдрагч амьтны амьдрах орчин, аюулгүй байдал, агаарын тоосжилт гээд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөх
- Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах;
- Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
- Хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах;
- Санамсар, болгоомжгүйн улмаас гал алдах, түймэр гарах. Энэ тохиолдолд экосистем бүхэлдээ хэвийн үйл ажиллагаагаа алдах аюултай.
- Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д хөдөлмөр аюулгүй байдлын талаар хангалттай тусгаж өгөөгүйгээс уурхайд осол аваар гарах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэх юм.

“Халнит” ХХК-ийн “Уужим булаг нэртэй элс-хайрганы орд ил аргаар ашиглах” төслөөс байгаль орчинд ахуйн бохир ус хөрсөнд алдагдах, орчны тоосжилт, хуурайшилт, газрын гадарга элэгдэл эвдрэлд өртөх, агаарын тоосжилт гээд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөх, газрын доорх усны нөөц хомсдох, гадаргын усны шинж чанар, ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвчид бохир ус, хатуу хог хаягдал, уурхай дээрх осол зэргээс үзүүлэх нөлөөлөл, орчны тоосжилт, дуу чимээний нөлөөлөл байгаа тул эдгээр нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд төслийн талбайд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024

“ХАЛНИТ” ХХК-ийн “Уужимбулаг нэртэй элс хайрганы ордыг ил аргаар ашиглах” төслийн БОННУ-ний ажлыг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д заасны дагуу болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасны дагуу хийж төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаа.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хуулинд заасны дагуу тус төлөвлөгөөнд нэгтгэн ашигласан болно.

4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчин, ажилчдын (хүний) эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг дараах хүснэгтээр харууллаа.

Тус байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго нь уурхайн үйл ажиллагаа явуулахад голлон анхаарах нь зүйтэй арга хэмжээг төлөвлөхийг урьтал болгох, мөн тухайн төслийн бүтээн байгуулалтын ажлын үе шатанд нөлөөллийн бүсийг хумих, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг гаргахыг зорилт болгон ажиллаа.

4.2. Хамрах хүрээ

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгэм хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- Төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах,
- Төслийн нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг тусгах
- Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- БОМТ түүний хэрэгжилтэнд оролцогч талуудыг тодорхойлж, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох

4.2.1. Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 БОМТ -нд өгсөн санал

Дархан-Уул аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраас өгсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд өгсөн санал нь нөхөн сэргээлтийн хэсэгт болон биологийн

олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талаарх зөвлөмжүүдийг тусгасан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд тухайн санал, зөвлөмж ажлуудыг бүрэн тусгаж ажиллаа.

4.3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ 2024

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	10
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх	Уурхайн дотоод тээвэр, хөрсний овоолгын талбайгаас дулааны улиралд болон тоос ихээр босох үед шүүрлийн усаар усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тоосжилт бууруулах бодис ашиглах	Агаарын чанар	мян.м ²	298.3	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Халнит” ХХК	Салхи ихтэй үед, хавар намар 7 хоногт 1-2 удаа	MNS 4585:2016 MNS 5885:2008 MNS ISO 4227:2002 MNS 6063:2010 MNS 4990:2000 УСТ 3384-92 УСТ 3600-83 MNS 4048-88 MNS 4585-2007 MNS ISO 4227 : 2002 MNS 3113 : 1981 MNS 5028 : 2001
	10 м/с ээс дээш салхитай үед газар шорооны ажил хийхгүй байх	Агаарын чанар	-	-	-		“Халнит” ХХК	10 м/с дээш салхитай өдрийн тоо 36-58 хоног	
	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч байршуулах байрлуулах	Агаарын чанар, хөрөн бүрхэвч	ш	5	50.000	250.000	“Халнит” ХХК	Уулын ажил эхлэхээс өмнө	
	Уурхайн дотоод замыг тэмдэг тэмдэгжүүлэх	Хөрсөн бүрхэвч	ш	5	50.000	250.000	“Халнит” ХХК	Уулын ажил эхлэхээс өмнө	
	Элс хайрга ангилаж, шигших цехийг зориулалтын сэндвич барилгад гүйцэтгэх	Хөрсөн бүрхэвч, агаар орчин	м ²	1000	Үйл ажиллагааны зардалд		“Халнит” ХХК	Олборлолт эхлэхээс өмнө	

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт, хийн хаягдал үүсэх, агаарын чанарт нөлөөлөх	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд оношлогоо, засвар үйлчилгээг тогтмол хийх	Агаарын чанар	ш	4	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Халнит” ХХК	Улиралд 1 удаа
Хийн хаягдал, Тоосжилт	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	4 цэгт	ОХШХ-т тусгагдсан.			“Халнит” ХХК	Жилд 2 удаа
Дуу чимээ								
Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг						руулах, арилгах арга хэмжээ		
Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Ус хэмнэх, байгаль орчноо хамгаалахад уриалсан, мэдээллийг харуулсан зурагт хуудас наах	Усны чанар, усны нөөц	ш	5	10.000	50.000	“Халнит” ХХК	Улирал бүр солих
	Ажилчдын унд-ахуйн зөөврийн усны зориулалтын сав ашиглах	Эрүүл ахуй, ундны усны чанар	ш	2	50.000	100.000	“Халнит” ХХК	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө
	Ажилчдын ундны зөөврийн савыг ариутгаж халдваргүйжүүлэлт хийх	Эрүүл ахуй, ундны усны чанар	1ш/удаа/жилд	1	100.000	100,000	“Халнит” ХХК	Улиралд 1 удаа
	Хараа голын эргийн энгийн хамгаалалтын дэглэмийг дагаж мөрдөх танилцуулах самбар	Усны чанар, усны нөөц	ш	2	100.000	200.000	“Халнит” ХХК	Төсөл хэрэгжих эхний жил
	Ажилчдын зөөврийн ариун цэврийн байгууламж ашиглах	Усны чанар, усны нөөц, хөрсөн бүрхэвч	ш	2	Бүтээн байгуулалтын зардалд тусгана		“Халнит” ХХК	Төсөл хэрэгжих эхний жил

	Ажилчдын унд-ахуйн, ариун цэврийн өрөөнд ус хэмнэх хошууч	Усны нөөц	ш	5	10.000	50.000	“Халнит” ХХК	Ажилчдын гар	
	Ажилчдын зөөврийн унд-ахуйн болон уурхайн шүүрлийн	Унд-ахуйн ус, шүүрлийн ус			ОХШХ-ны хөтөлбөрт тусгагдсан.	“Халнит” ХХК	Лабораторийн шижилгээний дүн	ОХШХ-ны хөтөлбөрт тусгагдсан.	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Хөрс элэгдэх, ургамлан нөмрөг талхлагдах Олон салаа зам гарах	Хатуу хучилттай авто зогсоол байгуулах зөвлөмж	Хөрс, ургамлан нөмрөг	-	тогтмол	1.000.000		“Халнит” ХХК	тогтмол	MNS 3297:1991 MNS 4919:2000 MNS 4920:2000 MNS 5850:2018 MNS 5914:2008 MNS5915:2008
	ШТМ, ШТС, засварын газрыг хатуу хучилттай болгох		-	тогтмол	Үйл ажиллагааны		“Халнит” ХХК	тогтмол	
	Уурхайн гадаад, дотоод тээврийг зориулалтын замаар зорчуулах, олон салаа зам гарахаас сэргийлэх, тэмдэг тэмдэгжүүлэх		м ²	7200	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах		“Халнит” ХХК		
Хөрс бохирдох,	Шимт хөрсний овоолгыг бүрхэц ургамалаар ургамалжуулах	Хог хаягдлын менежмент, хөрсөн	Иж бүрэн	1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах	“Халнит” ХХК	1ш/иж бүрэн		
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Дуу чимээ	Уурхайн үйл ажиллагааг шөнийн цагаар аль болох явуулахгүй байх, суурин ашиглагдах техникүүд богино зайн гэрлээ ашиглах хэрэгтэй	Амьтны аймаг	-	-	-		“Халнит” ХХК	тогтмол	-
Олон салаа зам гарах, хөрс эвдрэх, хөрсний бичил биетэн устгах	Уурхайн дотоод зам талбайг сайжруулах, тэмдэг тэмдэглэгээ хийх, нэгдсэн нэг замаар зорчуулах, олон салаа зам үүсэхээс сэргийлж ажиллах	Хөрсөн бүрхэвч, амьтны аймаг	ш	10	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгав.	“Халнит” ХХК	Уурхайн ажил эхлэхээс өмнө		MNS 4596 : 2014

Хөрс блхирдох, амьтад хордох	Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх	Хөрсөн бүрхэвч, амьны аймаг газрын доорх ус	ш удаа	2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав.	“Халнит” ХХК	Жилд 2 удаа	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
Нийт		1,000,000 төгрөг						

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай нь Дархан-Уул аймгийн Дархан сумын Малчин багийн нутаг дэвсгэрт байрладаг. Төслийн талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай болон түүний орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийнүйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

4.6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Халнит” ХХК нь Уужимбулагийн элс хайрганы ордын уурхайг 30 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тус уурхайг хугацаанаас өмнө хаах, олборлолтыг зогсоох үед заавал уурхайн хаалтын төлөвлөгөөг болосруулж, нөхөн сэргээлт хийх шаардлагатай. 2024 оны байдлаар төслийн талбайд буюу уурхайн байршилд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй ба зөвхөн шимт хөрсний овоолго дээр ургамал тарих ажил хийгдэнэ. Учир нь тухайн 2024 оны олборлолт явуулах талбайг тус ондоо багтааж олборлож дуусахгүй тул техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно.

4.7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөгөөг гаргасан байна. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэгч талууд дүйцүүлэн хамгааллын жилийн төсвийг тооцоолох, санхүүжилт хийхэд энэхүү 5 жилийн санхүүгийн төлөвлөлтийг үндэслэнэ. Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төсөвт дараах зардлууд орно. Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүрийн нийлбэр оноогоор зардлыг тооцно.

2024 онд төсөвлөгдөх дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал 6,612,700 төг

4.8. Тэрбум мод

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дархан-Уул аймаг Дархан сумын Уужимбулаг багийн нутагт мод тарихаар төлөвлөөд байна.

Хүснэгт 8. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн ажил

№	Агуулга	Хийгдэх ажлууд	Зардалт ажил
1	Өмнөх жилүүдэд мод тарьсан талбайд нэмэлтээр мод тарих	100 ш мод тарина	Тухайн үед гарах зардлаар
Нийт зардал			

4.9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Уужимбулаг элс хайрганы орд нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18000 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй. “Халнит” ХХК нь уурхайн гэнэтийн ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллана.

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, буУРУУлах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	
Гэнэтийн болзошгүй осол эрсдэл									
1	Газар хөдлөлт	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	ш удаа	1	100.000	100.000	1ш удаа	Монголын засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
2	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай	ш	1	300.000	300.000	1ш удаа	Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм
3	Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай	иж бүрэн	-	500.000	500.000	1 удаа иж бүрэн	Дэд бүтцийн сайдын 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 134 дугаар тушаалаар батлагдсан Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам БНБД 33-01-03
4	Шороон шуурга	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай	-	тогтмол	-	-	тогтмол	
5	Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын	Төслийн талбай	боодол	10	20.000	200.000	тогтмол	

		хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)							
6	Нефт болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг	-	ТОГТМОЛ	-	-	ТОГТМОЛ	УУХҮС, ХНХС-ын хамтарсан 2019 оны А/231, А/368 дугаар тушаалаар Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм
Нийт								1.100.000 төгрөг	

4.10.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Ахуйн хог хаягдал	Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах, түр хадгалах сав байршуулах	Хогийн хаягдлын цэгт	4 ш/удаа	150.000	600.000	“Халнит” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” БОАЖС-ын 2018 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам
	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Дархан сумын ТҮК-тай байгуулж сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөх	Хатуу хог хаягдал	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Халнит” ХХК	
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрт нь	-	-	“Халнит” ХХК	
	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Жилд 2 удаа	100.000	200.000	“Халнит” ХХК	
	Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	Төслийн хүрээнд	Тогтмол	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		“Халнит” ХХК	
Ахуйн болон аюултай хог хаягдал	Хог хаягдлын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бий болгох	Төслийн хүрээнд	Тогтмол	-	-	“Халнит” ХХК	
	Хог хаягдлын тайлан мэдээг улиралд 1 удаа гаргах	Төслийн хүрээнд	Улиралд 1 удаа	-	-	“Халнит” ХХК	
Аюултай хог хаягдал	Техникийн хэрэгцээнд ашигласан дизелийн масло болон бусад тос, тосолгоо материал, аюултай хог хаягдлыг зайлуулах	Төслийн хүрээнд	Тогтмол	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		“Халнит” ХХК	
Нийт				800.000 төгрөг			

4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төгрөг	2024 онд хэрэгжүүлэх хувиар			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Cap ...	Cap ...	Cap ...		
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	-	+	+		Захирал Уурхайн дарга	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	250.000	+	+		Уурхайн дарга Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани	Ажилчдад байгаль орчныг хамгаалах мэдлэг олгох, байгаль болон уурхайн үйл ажиллагаанаас үүсэн гарах гэнэтийн осол эрслээс сэргийлэх зэрэг мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулах. 2020 онд 2 удаа, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах боломжтой.
3	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	+	+		Захирал Уурхайн дарга	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	2.500.000	+	+		Захирал Уурхайн дарга	Ажиллагсдыг мэргэжлийн эмчийн үзлэгт тогтмол харуулж ажиллах
5	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Дархан-Уул аймгийн ЗДТГ-т хүргэн өгч байх	-	+	+		Захирал Уурхайн дарга	-
6	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр	Дотоод зардлаар	+	+		Захирал Уурхайн дарга	“Газрын төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийг дагаж мөрдөх

7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах	-	+	+		Захирал Уурхайн дарга	-
8	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан хорооны иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд дэмжиж туслах, нийгмийн хариуцлагын гэрээ	-	+	+		Захирал Уурхайн дарга	-
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	-	+	+		Захирал Уурхайн дарга	“Хог хаягдлын тухай хууль” “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам”
10	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	-	+	+		Захирал Уурхайн дарга	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
Нийт						2.750.000 төгрөг	

4.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	
Байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ийн биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сард багтаана.	Шинжээчдийн дүгнэлт	Аймгийн байгаль орчны газар	“Халнит” ХХК	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Сум	“Халнит” ХХК	
Орон нутаг, төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	“Халнит” ХХК	
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Улаанбаатар хот	“Халнит” ХХК	

5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Халнит” ХХК-ийн “Уужимбулаг элс хайрганы ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд боловсруулан оруулав.

5.1. Агаар орчин

5.1.1. Хяналт шинжилгээ явуулах шаардлага:

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч сувилуулагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

5.1.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч

Хяналт шинжилгээ явуулах шаардлага:

Хөрсний бохирдлын түвшинг гадаад, дотоодын итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.


5.1.3. Ургамлан нөмрөг

Хяналт шинжилгээ явуулах шаардлага:

Барилгын ажлын үед эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

5.1.4. Усны чанар, нөөц

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.



Зураг 8. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.1.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂ NO, NO _x) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO ₂), CO, HCN, O ₂ .	мкг/м ³	Уурхайн карьер, дотоод тээврийн зам, уурхайн тосгон, хөрсний овоолго <i>нийт 5 цэгт</i>	Жилд 1 удаа	100.000	500.000	“Халнит” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	УСТ 3384-92 УСТ 3600-83 MNS 4048-88 MNS 4585-2007 MNS ISO 4227 : 2002 MNS 3113 : 1981 MNS 5028 : 2001
1.2.	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм							
1.3	Дуу чимээ	дБА							
2. УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.2	Шүүрлийн усны шинжилгээ		Төслийн талбайгаас гарах шүүрлийн уснаас <i>2 дээж</i>	Жилд 2 удаа	100.000	400.000	“Халнит” ХХК		
3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
3.	Ялзмаг агууламж Урвалын орчин Хөрсний физик, химийн шинж чанар Хөрсний хүнд металлын агууламж Хөрсний микробиологийн шинжилгээ Нийт азот, фосфор Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн	мг/кг	Шимт хөрсний овоолго, уурхайн карьер, дотоод тээврийн зам, уурхайн тосгон, хөрсний овоолго <i>нийт 5 цэгт</i>	Жилд 1 удаа	100.0	500.000	“Халнит” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	УСТ 3298-90 УСТ 3297-91 MNS 5850-2008 MNS ISO 10390 : 2001 MNS (ISO) 11260 : 2000 MNS ISO 11269-1 : 2002 MNS 5546 : 2005 MNS 3298 : 1991 MNS 3243 : 1989 MNS 5918 : 2008 MNS 2490 : 1977
4. УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									

5.	Эдэлбэр газрын ургамалжилтын байдал, хогийн ургамал ургасан эсэх, ургамлын тусгаг бүрхэвч, ургамлан нөмрөгийн талхагдал, олон наст ургамлын гарц, ургацын өндөр		Лицензийн талбайн хил дотор 5 цэг, нөлөөлөлд өртөгч бүсэд 5 цэгт <i>нийт 10 цэгт</i>	Жилд 1 удаа	30.000	300.000	“Халнит” ХХК		УСТ 17.5.1.18 УСТ 17.5.1.19-92 MNS 5914-2008 MNS 5918-2008 MNS 6191 : 2010 MNS 5916 : 2008
Нийт						1.700.000 төгрөг			

5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Зардлын хэлбэр	5 жил /.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	Тус онд хийгдэхгүй
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	6,612,700
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын зардал	-
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,100,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	800,000
Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	2,750,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Байгаль орчныг хамгаалахаар төлөвлөсөн 2024 оны зардал	12,262,700
Орчны хяналт шинжилгээний зардал	1,700,000

6. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
3. ТЭЗҮ батлагдсан шийдвэр
4. Уулын ажлын төлөвлөгөөний батлагдсан шийдвэр
5. БОМТ барьцаа хөрөнгө байршуулсан мэдээлэл